



ИНД - 129

ИРГЭНИЙ НИСЭХИЙН БАГЦ ДҮРЭМ

**ГАДААДЫН АГААРЫН ТЭЭВЭРЛЭГЧ –
ГЭРЧИЛГЭЭЖҮҮЛЭЛТ**

ДҮРМИЙН ТАЙЛБАР

ИНД-129-ийн зорилго нь Монгол Улсад дараалсан 28 хоногийн дотор 2-оос дээш удаа хөөрөлт, буулт үйлдэх эсхүл Монгол Улсад дараалсан 365 хоногийн дотор 8-аас дээш удаа хөөрөлт, буулт үйлдэх гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах аливаа этгээдийг гэрчилгээжүүлэх болон үйл ажиллагаанд нь тавих шаардлагыг тодорхойлоход оршино.

Энэ дүрэм нь нүүлгэн шилжүүлэлтийг багтаасан түргэн тусламжийн, эсхүл эмнэлгийн хангалт эсхүл биеийн эрхтэн тээвэрлэх зорилгоор явуулах үйл ажиллагаанд хамаарахгүй.

Энэ дүрэм нь Иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Сайдын баталсан ИНД-129-ийн цахим хувилбар бөгөөд зөвхөн ишлэл хийх зорилгоор хэрэглэнэ. Хүчин төгөлдөр ИНД-129, түүний өөрчлөлтийн хуулбарыг ИНЕГ-аас, эсхүл www.mcaa.gov.mn веб сайтаас татаж авах боломжтой.

Мэдээлэл

Гишүүн улсуудын иргэний нисэхийн дүрмийг сайжруулах замаар иргэний нисэхийн салбарт нэгдсэн нэг дүрмийн зохицуулалтад шилжих тухай Олон улсын иргэний нисэхийн байгууллага /ИКАО/-ын 1992 оны 29-р чуулганы А29-3 тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор, Монгол Улс болон Шинэ Зеланд улсын ИНЕГ-ын хооронд 1999 оны 5 дугаар сарын 6-ны өдөр байгуулсан “Техникийн Хамтын Ажиллагааны Санамж Бичиг”-ийг үндэслэн Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрмийг Шинэ Зеландын Иргэний нисэхийн дүрэмд уялдуулан гаргасан болно.

ИНД-129 нь анх 2006 оны 01-р сарын 16-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Энэхүү ИНД-129-ийн Хэвлэл 2-г Шинэ Зеландын Part 129, 2010 оны 03-р сарын 25-ний өдрийн Өөрчлөлт 7-д үндэслэн боловсруулсан болно.

Тэмдэглэл: ИНД-129-г англи болон монгол хэл дээр боловсруулсан ба эдгээрийн хооронд зөрүү гарсан тохиолдолд англи хувилбар нь давамгайлна.

ГАРЧИГ

А Бүлэг — Ерөнхий зүйл	5
129.1 Үйлчлэх хүрээ	5
129.3 Нэр томъёоны тодорхойлолт	5
129.5 Гэрчилгээнд тавигдах шаардлага	5
129.7 Өргөдөл гаргах.....	5
129.9 Гэрчилгээ олгох	6
129.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх.....	6
129.13 Үйл ажиллагааны тодорхойлолт	6
129.15 Гэрчилгээний үргэлжлэх хугацаа	7
129.17 Үйл ажиллагаагаа зогсоох мэдэгдэл.....	7
129.19 Гэрчилгээг шинэчлэх.....	7
Б Бүлэг — Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлага.....	8
129.51 Эрх олгосон бичиг баримт	8
129.53 Үзүүлэх эсхүл шалгах нислэг.....	8
129.55 Осол, зөрчлийг мэдээлэх.....	8
129.57 Боловсон хүчний бүртгэл.....	8
129.59 Тоног төхөөрөмжийн хангалтын бүртгэл	9
129.61 Агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр.....	9
129.63 Гадаадын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар.....	9
В Бүлэг — Үйл ажиллагаанд тавигдах шаардлага.....	11
129.101 Байнгын хэрэгжилт	11
129.103 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад орох өөрчлөлт.....	11
129.105 Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)	12
129.107 Аэродром ашиглах	12
129.109 Ослын байршил дамжуулагч.....	13

А Бүлэг — Ерөнхий зүйл

129.1 Үйлчлэх хүрээ

(a) Энэ зүйлийн (b)-д зааснаас бусад тохиолдолд, гадаадын агаарын тээврийн дараах үйл ажиллагаа эрхлэх этгээд энэхүү дүрмээр гэрчилгээжнэ:

- (1) Монгол Улсад дараалсан 28 хоногийн дотор 2-оос дээш удаа хөөрөлт, буулт үйлдэх; эсхүл
- (2) Монгол Улсад дараалсан 365 хоногийн дотор 8-аас дээш удаа хөөрөлт, буулт үйлдэх.

(b) Энэ дүрэм нь нүүлгэн шилжүүлэлтийг багтаасан түргэн тусламжийн, эсхүл эмнэлгийн хангалт эсхүл биеийн эрхтэн тээвэрлэх зорилгоор явуулах үйл ажиллагаанд хамаарахгүй.

129.3 Нэр томъёоны тодорхойлолт

Энэ дүрмэнд —

Гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гэж Монгол Улсад байнга оршин суух хаяггүй этгээдийн эрхлэн явуулах дараах агаарын тээврийн үйл ажиллагааг хэлнэ –

- (1) Монгол Улс руу эсхүл Монгол Улсаас; эсхүл
- (2) Монгол Улс руу эсхүл Монгол Улсаас үйлдэх нислэгийн үйл ажиллагааны хүрээнд Монгол Улсын нутаг дэвсгэр дотор.

129.5 Гэрчилгээнд тавигдах шаардлага

(a) Энэ дүрмээр олгосон Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний дагуу болон холбогдох эрхийн хүрээнээс бусад үйл ажиллагаа явуулахыг аливаа этгээдэд хориглоно.

(b) Хамааралгүй.

129.7 Өргөдөл гаргах

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь:

- (1) САА 24129/01 өргөдлийн маягтыг бөглөж, холбогдох төлбөрийн баримтын хамт Даргад үйл ажиллагаагаа явуулахаар төлөвлөж буй өдрөөс 90-с доошгүй хоногийн өмнө, эсхүл Дарга боломжтой гэж үзсэн тохиолдолд түүнээс богино хугацааны өмнө ирүүлнэ;
- (2) энэ дүрмийн 129.13(b)-д шаардсан Үйл ажиллагааны тодорхойлолтонд шаардагдах дэлгэрэнгүй мэдээллийг ирүүлнэ;

- (3) энэ дүрмийн 129.63-д шаардсан байгууллагын Ерөнхий зааврын, Монгол Улс руу, Монгол Улсаас, эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дотор үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бүлэг, хэсгийг хянуулахаар ирүүлнэ;
- (4) энэ дүрмийн 129.51-д шаардсан зөвшөөрлийн нотлох баримтыг ирүүлнэ.

129.9 Гэрчилгээ олгох

Дарга нь дараах шаардлагыг хангасан өргөдөл гаргагчид Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгоно:

- (1) энэ дүрмийн Бүлэг “Б”-ийн шаардлагыг хангасан;
- (2) өргөдөл гаргагч хувь хүн болон түүний удирдах албан тушаалтан, эсхүл энэ дүрмийн 129.63 (1) ба (2)-т заасны дагуу томилогдохоор нэр дэвшсэн хүмүүс нь тохирох зөв хүний шаардлагыг хангасан;
- (3) энэ дүрмийн 129.51-д заагдсан ИКАО-ийн Хэлэлцэн тохирогч улс, эсхүл улс орон эсхүл бүс нутаг нь санал болгож буй гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаанд хамаарал бүхий Чикагогийн конвенциор хүлээсэн чиг үүргээ хангаж байгаа бол;
- (4) гэрчилгээ олгосноор нисэхийн аюулгүй ажиллагаанд харшлахгүй байх.

129.11 Гэрчилгээ эзэмшигчийн эрх

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь тухайн гэрчилгээ эзэмшигчийн явуулж болох гадаадын агаарын тээврийн үйл ажиллагааны эрхийг тодорхойлно.

129.13 Үйл ажиллагааны тодорхойлолт

(а) Энэ дүрмийн дагуу олгосон Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг энэ зүйлийн (b)-д заасан Үйл ажиллагааны тодорхойлолт заавал дагалдана.

(b) Үйл ажиллагааны тодорхойлолт нь дараах мэдээллийг агуулна:

- (1) гэрчилгээ эзэмшигчийн үйл ажиллагаа явуулах үндсэн байршлын дэлгэрэнгүй;
- (2) хэрэв ялгаатай бол, Дарга болон гэрчилгээ эзэмшигч нарын хооронд харилцах гол этгээдтэй холбоо барих хаяг;
- (3) гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улсад үйл ажиллагаагаа явуулах хаяг;
- (4) гэрчилгээ эзэмшигч үйл ажиллагаагаа өөр бизнесийн нэрийн дор явуулах бол тухайн нэр, хаяг;
- (5) ашиглахыг зөвшөөрсөн агаарын хөлгийн маяг;
- (6) зөвшөөрөгдсөн үйл ажиллагааны төрөл;

- (7) үйл ажиллагаа явуулах зөвшөөрөгдсөн бүс нутаг, нислэгийн чиглэл болон хязгаарлалтууд;
- (8) ашиглах үндсэн аэродром болон нөөц аэродромын нэрс;
- (9) энэ дүрэм болон бусад дүрмийн шаардлагуудаас чөлөөлөгдөх аливаа нөхцлүүд;
- (10) тухайн нөхцөл байдлыг бататгах үүднээс Даргын шаардлагатай гэж үзсэн аливаа бусад зүйлс.

129.15 Гэрчилгээний үргэлжлэх хугацаа

- (a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг 5 хүртэл жилийн хугацаагаар олгож эсхүл шинэчилж болно.
- (b) Гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, эсхүл Дарга гэрчилгээг түр түдгэлзүүлэх эсхүл хүчингүй болгохоос бусад тохиолдолд Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ нь хүчин төгөлдөр байна.
- (c) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч гэрчилгээний хүчин төгөлдөр хугацаа дууссан, эсхүл хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээг Даргад нэн даруй хураалгана.
- (d) Гэрчилгээг түр түдгэлзүүлсэн тохиолдолд Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч холбогдох тэмдэглэлийг хийлгэхээр гэрчилгээг Даргад нэн даруй ирүүлнэ.

129.17 Үйл ажиллагаагаа зогсоох мэдэгдэл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн хүрээнд явуулж буй үйл ажиллагаагаа зогсоох тохиолдолд энэ тухайгаа 30-аас доошгүй хоногийн өмнө Даргад бичгээр мэдэгдэнэ.

129.19 Гэрчилгээг шинэчлэх

- (a) Гэрчилгээ эзэмшигч нь Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээг шинэчлэх тухай өргөдлийг САА 24129/01 маягтын дагуу гаргана.
- (b) Энэ зүйлийн (a)-д шаардсан өргөдлийг гэрчилгээ эзэмшигч нь гэрчилгээнд заасан өргөдөл гаргах хугацаанаас өмнө, эсхүл хугацаа заагаагүй бол гэрчилгээний хүчинтэй хугацаа дуусахаас 60-аас доошгүй хоногийн өмнө Даргад ирүүлсэн байна.

Б Бүлэг — Гэрчилгээжүүлэлтэд тавигдах шаардлага

129.51 Эрх олгосон бичиг баримт

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгосон ИКАО-ийн Хэлэлцэн тохирогч улс, эсхүл улс орон эсхүл бүс нутгийн эрх бүхий байгууллагаас олгосон хүчин төгөлдөр Агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эсхүл Дарга хүлээн зөвшөөрөхүйц ижил хэмжээний бичиг баримт эзэмшдэг байна.

129.53 Үзүүлэх эсхүл шалгах нислэг

(a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр, эсхүл гэрчилгээндээ нэмэлт өөрчлөлт оруулахаар өргөдөл гаргагч нь Дарга шаардсан тохиолдолд аливаа хамаарал бүхий тогтоогдсон шаардлагуудыг хангаж байгааг нотлох үзүүлэх эсхүл шалгах нислэг үйлдэнэ.

(b) Үзүүлэх буюу шалгах нислэгийг Даргын хүлээн зөвшөөрсөн аргачлалаар гүйцэтгэнэ.

129.55 Осол, зөрчлийг мэдээлэх

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт аливаа осол, зөрчилд өртсөн тохиолдолд Даргад ИНД-12-ын дагуу мэдээлэх журамтай байна.

129.57 Боловсон хүчний бүртгэл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь дараах зүйлийг бататгах бүртгэлийн журмыг тогтоосон байна:

- (1) Монгол Улсад ажиллуулж байгаа, гэрээт, эсхүл хөлсөлсөн, дор заасанд хамаарах ажилтан бүрийн хувьд бүртгэлийг үнэн зөв хөтлөх:
 - (i) хариуцсан ажил үүргээ гүйцэтгэхэд нисэхийн мэргэжлийн үнэмлэх эсхүл зэрэглэл эзэмшсэн байх шаардлагатай ажилтан;
 - (ii) Даргаас шилжигдсэн аливаа эрх, үүргийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан;
 - (iii) гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон аливаа эрхийн дагуу ажил үүрэг гүйцэтгэж буй ажилтан.
- (2) бүртгэл нь дараах дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байна:
 - (i) энэ зүйлийн (1) хэсэгт заагдсан ажилтан бүрийн хамаарах мэргэшил, дадлага туршлага, сургалтын талаар;

- (ii) энэ зүйлийн (1)(i)-д заасан үнэмлэх, зэрэглэлийн үйлчлэх хүрээ, хүчинтэй хугацаа болон хадгалалтын талаар;
 - (iii) энэ зүйлийн (1)(ii)-д заасан шилжигдсэн эрх, үүргийн талаар;
 - (iv) энэ зүйлийн (1)(iii)-д заасан гэрчилгээ эзэмшигчээс олгогдсон эрхийн талаар.
- (3) дараах тохиолдолд тухайн ажилтны талаарх бүртгэлийг тухайн өдрөөс хойш нэг жилийн хугацаагаар, эсхүл Дарга шаардлагатай гэж үзсэн илүү урт хугацаагаар Монгол Улсад хадгалах —
- (i) үнэмлэх, зэрэглэл шаардсан үүрэгт ажлаа гүйцэтгэхээ болих, эсхүл
 - (ii) шилжигдсэн болон олгогдсон эрхийг шилжүүлсэн.

129.59 Тоног төхөөрөмжийн хангалтын бүртгэл

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь —

- (1) гэрчилгээнд тодорхойлсон үйл ажиллагааг гүйцэтгэхэд ашиглагддаг, нислэгийн аюулгүй ажиллагаанд онцгой нөлөөлөх тоног төхөөрөмжинд хийгдсэн тохиргоо, үзлэг шалгалт болон туршилтын талаархи дэлгэрэнгүй мэдээллийн бүртгэлийг бататгах журмыг тогтоосон байна;
- (2) энэ зүйлийн (1)-д заагдсан мэдээллийн бүртгэлийг бичигдсэн өдрөөс эхлэн 2 жилийн хугацаанд Монгол Улсад хадгална.

129.61 Агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь энэ дүрмийн хүрээнд тээврийн хөлс төлсөн 10 эсхүл түүнээс дээш зорчигчийн суудалтай агаарын хөлгөөр нислэгийн үйл ажиллагаа явуулахаар төлөвлөсөн бол ИНД-108-ын шаардлагыг хангасан Аюулгүй байдлын хөтөлбөртэй байна.

129.63 Гадаадын агаарын тээвэрлэгчийн Ерөнхий заавар

(а) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшихээр өргөдөл гаргагч нь өөрийн байгууллагын Ерөнхий зааварт дараах мэдээлэл орсон эсэхийг бататгасан байна —

- (1) Монгол Улсад ажиллах удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал ба нэрс;
- (2) гэрчилгээ эзэмшигч энэ дүрмийн эсхүл бусад дүрмийн шаардлагуудыг хангаж байгааг бататгах үүрэг хүлээсэн удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын албан тушаал ба нэрс;

- (3) энэ зүйлийн (а)(1) ба (2)-т заасан удирдах ажилтан, эсхүл ажилтнуудын үүрэг, хариуцлага, үүнд өргөдөл гаргагч байгууллагын нэрийн өмнөөс Даргатай шууд харьцах ажлын үүрэг хариуцлага багтсан байна;
 - (4) гадаадын агаарын тээврийн үйл ажиллагааг гүйцэтгэх зорилгоор байгууллагын ажилтнуудын Монгол Улсын нутаг дэвсгэр дотор байрлаж байгаа байршил тус бүрийн үйл ажиллагааны цар хүрээний нэгдсэн танилцуулга;
 - (5) энэ зүйлийн (а)(1) ба (2)-т заасан удирдах ажилтнуудын үүрэг хариуцлагын хамаарлыг харуулсан, болон энэ зүйлийн (а)(4)-т заасан байршил тус бүрээр задалсан байгууллагын бүтцийн зураг;
 - (6) энэ зүйлийн (а)(4)-т заасан байршил тус бүр дэх өргөдөл гаргагч байгууллагын ажилтнуудын нэгдсэн бүтэц;
 - (7) байнга оршин суух хаяг бүхий улс дахь үйл ажиллагааны үндсэн байршил, болон шаардлагатай тохиолдолд үйл ажиллагааны болон техник үйлчилгээний үндсэн баазын талаарх мэдээлэл;
 - (8) өргөдөл гаргагч байгууллагад тавих хяналтыг хэрэгжүүлж буй иргэний нисэхийн эрх бүхий байгууллагын холбогдох этгээдийн холбоо барих мэдээлэл;
 - (9) дараах дүрмийн заалтаар шаардсан журмууд —
 - (i) 129.55-д заагдсан осол, зөрчлийн талаар;
 - (ii) 129.57-д заагдсан боловсон хүчний бүртгэлийн талаар;
 - (iii) 129.59-д заагдсан хангалтын бүртгэлийн талаар;
 - (10) 129.61-ээр шаардсан бол, агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөр;
 - (11) Ерөнхий зааврыг баталгаажуулах, хянах, нэмэлт өөрчлөлт оруулах, түгээх журмууд;
 - (12) энэ дүрмийн хүрээнд шаардлага хангахуйц үйл ажиллагаа явуулахад шаардлагатай бусад мэдээлэл.
- (b) Өргөдөл гаргагчийн байгууллагын Ерөнхий зааврын гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаанд хамаарах хэсгүүд нь Даргад хүлээн зөвшөөрөхүйц биш бол Дарга Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ олгохгүй.

В Бүлэг — Үйл ажиллагаанд тавигдах шаардлага

129.101 Байнгын хэрэгжилт

- (a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэ дүрмийн 129.13-д заасан Үйл ажиллагааны тодорхойлолтыг дагаж мөрдөнө.
- (b) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь дараах үүрэгтэй —
- (1) энэ дүрмийн Б Бүлэгт заасан шаардлагуудыг байнга хангах болон стандартуудыг дагаж мөрдөх;
 - (2) энэ дүрмийн 129.7(3)-ийн дагуу шаардсан Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээнд хамаарал бүхий гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын холбогдох бүлэг, хэсгүүдийн болон үйл ажиллагааны тодорхойлолтын хүчин төгөлдөр, нэгээс доошгүй хувийг Ерөнхий зааварт тусгасан Монгол дахь үйл ажиллагааны томоохон байршил бүрт байлгах;
 - (3) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт тусгасан журам бүрийг мөрдөх ажиллах;
 - (4) тухайн ажилтан ажил үүргээ гүйцэтгэхэд шаардагдах, гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааврын холбогдох хэсгүүд болон энэхүү дүрмийн хүрээнд Даргаас олгосон үйл ажиллагааны тодорхойлолтыг ажилтнуудад хэрэглэх боломжтой байлгах.
- (c) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь 129.63-д шаардсан мэдээллийг багтаасан байгууллагын Ерөнхий зааврыг Даргын хүсэлтээр бэлэн байлгана.

129.103 Гэрчилгээ эзэмшигч байгууллагад орох өөрчлөлт

- (a) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь:
- (1) гэрчилгээ эзэмшигчийн Монгол Улс руу, Монгол Улсаас эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дотор явуулах үйл ажиллагааны хүчин төгөлдөр байдлаа хадгалж үлдэх зорилгоор, байгууллагын Ерөнхий заавартаа шаардлагатай нэмэлт өөрчлөлтийг оруулсан эсэхийг бататгана;
 - (2) гэрчилгээ эзэмшигчийн Ерөнхий зааварт оруулсан аливаа нэмэлт өөрчлөлт нь энэ дүрмийн холбогдох шаардлагад нийцэж байгаа болон Ерөнхий зааварт тусгагдсан нэмэлт өөрчлөлт оруулах журмын дагуу хийгдсэн эсэхийг бататгана.
- (b) Гэрчилгээ эзэмшигч нь дараах аль нэг өөрчлөлтийг хийхээр төлөвлөж байгаа бол Даргад урьдчилан мэдэгдэж, хүлээн зөвшөөрүүлсэн байх шаардлагатай:
- (1) дүрмийн 129.63(a)(1)-ийн дагуу томилогдох удирдах албан тушаалтанг өөрчлөх;
 - (2) гэрчилгээ эзэмшигчийн агаарын тээврийн үйл ажиллагаа явуулах Монгол Улс дахь үндсэн байршил солигдох;

- (3) Монгол Улс руу, Монгол Улсаас эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дотор явуулах үйл ажиллагааны цар хүрээ өөрчлөгдөх;
- (4) дүрмийн 129.61-ээр шаардсан агаарын тээвэрлэгчийн аюулгүй байдлын хөтөлбөрт өөрчлөлт орох.

(c) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч энэ зүйлийн (b)-д тусгасан аливаа өөрчлөлтийг хийх талаарх өргөдлөө САА 24129/01 маягтын дагуу гаргана.

(d) Дарга, энэ зүйлийн (b)-д заасан өөрчлөлтийг хийх явцад, эсхүл хийгдсэний дараа аливаа нэмэлт нөхцөлийг тогтоож болно.

(e) Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь энэ зүйлийн (d)-д заасны дагуу Даргын тогтоосон аливаа нөхцөлийг дагаж мөрдөнө.

(f) Энэ зүйлийн (b)-д дурдагдсан аливаа өөрчлөлт нь гэрчилгээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг шаардаж байвал, гэрчилгээ эзэмшигч гэрчилгээг Даргад нэн даруй хүргүүлнэ.

(g) Дарга, нисэхийн аюулгүй ажиллагаа эсхүл аюулгүй байдлын үүднээс зайлшгүй гэж үзсэн аливаа нэмэлт өөрчлөлтийг гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч байгууллагын Ерөнхий зааварт оруулсан байна.

129.105 Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II)

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь, хөөрөлтийн зөвшөөрөгдсөн дээд жин нь 5700 кг-аас их, эсхүл 19-өөс дээш зорчигчийн суудалтай турбинт хөдөлгүүрт агаарын хөлгөөр Монгол Улс руу, Монгол Улсаас эсхүл Монгол Улсын нутаг дэвсгэр дотор олгогдсон гэрчилгээний дагуу нислэг үйлдэх бол тухайн агаарын хөлөгт FAA TSO-C119b-д заасан шаардлагыг хангасан Агаарт мөргөлдөхөөс урьдчилан сэргийлэх систем (ACAS II) суурилагдсан гэдгийг бататгана.

129.107 Аэродром ашиглах

Гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигч нь уг гэрчилгээгээр олгогдсон зөвшөөрлийн хүрээнд гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа гүйцэтгэх агаарын хөлөг Монгол Улсын нутаг дэвсгэрт хөөрөлт, буултад дараах шаардлага хангаагүй аэродром ашиглаагүй болохыг бататгана —

- (1) тухайн аэродромд ашиглах хөөрч, буух зурвас (ХБЗ) нь ИНД-139-ийн Хавсралт А.1-ийн дагуу зурвасны төгсгөл бүрт ХБЗ-ны төгсгөлийн аюулгүй талбайгүй; эсхүл
- (2) хэрэв хөөрч, буух зурвас нь энэ зүйлийн (1)-д заасан ХБЗ-ны төгсгөлийн аюулгүй талбайгүй бол, гэрчилгээ эзэмшигч нь тухайн агаарын хөлгийн хөөрөлт буултын тооцоог хөөрч буух зурвасны давж буух төгсгөлд RESA

нь 90 метр байхаар тухайн зурвасны илтгэгдсэн зохих зайг багасгасан байдлаар тооцсон гэдгийг бататгаагүй бол.

129.109 Ослын байршил дамжуулагч

(a) Онгоцоор гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа явуулж буй гадаадын агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ эзэмшигчийн хувьд 91.529(a)-д заасан шаардлага хамаарахгүй.

(b) Энэ зүйлийн (a)-г үл харгалзан, гэрчилгээ эзэмшигч нь дараах шаардлагын дагуу тоноглогдоогүй онгоцоор гадаадын агаарын тээврийн үйл ажиллагаа явуулахгүй:

- (1) хэрэв тухайн онгоц нь 19-с дээш зорчигч тээвэрлэх зөвшөөрөлтэй ба уг агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх 2008 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс өмнө олгогдсон бол нэгээс багагүй автомат ELT эсхүл дурын төрлийн хоёр ELT-ээр тоноглогдсон байна;
- (2) хэрэв тухайн онгоц нь 19-с дээш зорчигч тээвэрлэх зөвшөөрөлтэй ба уг агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх 2008 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хойш олгогдсон бол хоёроос багагүй ELT-ээр тоноглогдсон байх ба эдгээрийн нэг нь заавал автомат байна;
- (3) хэрэв тухайн онгоц нь 19 ба түүнээс доош зорчигч тээвэрлэх зөвшөөрөлтэй ба уг агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх 2008 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс өмнө олгогдсон бол дурын төрлийн нэгээс багагүй ELT-ээр тоноглогдсон байна;
- (4) хэрэв тухайн онгоц нь 19 ба түүнээс доош зорчигч тээвэрлэх зөвшөөрөлтэй ба уг агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ анх 2008 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс хойш олгогдсон бол нэгээс багагүй автомат ELT-ээр тоноглогдсон байна;
- (5) агаарын хөлөгт суурилуулсан эсхүл авч яваа ELT бүр нь —
 - (i) АНУ-ын TSO C-126-д заасан шаардлагыг хангасан байна;
 - (ii) 406 мгц болон 121.5 мгц давтамжийн аль алин дээр нь дамжуулна.